



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/391

Номгон

Аймгийн Засаг даргын 2015 оны "Газар нэмж  
эзэмшүүлэх тухай" 309 дүгээр захирамжид  
өөрчлөлт оруулах тухай

Аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 309 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтад "Навтгар хайрхан" ХХК-д нэмж эзэмшүүлэх 2278 м2 газрыг тус компаний захирал Ч.Наранбаатарт нэмж эзэмшүүлсэн тул Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн "Газар нэмж эзэмшүүлэх тухай" 309 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

2.Баянхонгор сум, Номгон 1 дүгээр баг, Нисэхийн гудамж-1, 114 тоот хаягт байршилтай "Навтгар хайрхан" ХХК-ний эзэмшиж буй (2006952) 3000 м2 эзэмшил газар дээр 2278 м2 газрыг нэмж эзэмшүүлсүгэй.

3.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигч "Навтгар хайрхан" ХХК (Ч.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010983